



ТӨВ АЙМГИЙН
ЗУУНМОД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 18 өдөр

Дугаар А/428

Зуунмод

Ажлын хэсэг байгуулах
тухай

Монгол улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль”-ийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Ногоон хөгжил-Баялаг бүтээгчдийн дэмжих” урианы жил, Зуунмод хотын 80 жилийн ой, Нийтийн аж ахуй байгуулагдсаны 90 жилийн ойн хүрээнд үсчин, гоо сайханч, маникюрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэдийн ур чадварыг нэмэгдүүлэн, харилцан туршлага солилцож мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх зорилгоор “Үсчин, гоо сайханч, маникюр нарын ур чадварын уралдаан”-ыг 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулсугай.

2. Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:	Н.Энхсайхан	-Засаг даргын орлогч
Гишүүдэд:	Д.Өнөрбаяр	-Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн
	Г.Уянга	-Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн
	Ш.Батмөнх	-Соёлын төвийн эрхлэгч
	Б.Лхагвасүрэн	-Аймгийн ХХААГ-ын үйлдвэр худалдаа албаны дарга /зөвшилцсөнөөр/
	Б.Уянга	-Аймгийн ХХААГ-ын мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/
	Г.Уянга	-Цахим үйлчилгээний ажилтан
	С.Дарьсүрэн	- Зуунмод сумын үсчдийн холбооны тэргүүн
	М.Жаргалтогтох	-Зуунмод сумын үсчдийн холбооны тэргүүлэгч
	П.Болормаа	-Зуунмод сумын үсчдийн холбооны тэргүүлэгч
Нарийн бичгийн дарга:	Б.Батжаргал	-Хөдөө аж ахуйн тасгийн дарга


3. “Үсчин, гоо сайханч, маникюр нарын ур чадварын уралдаан”-ыг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг 1 дүгээр, төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

4. Уралдаанд шаардагдах зардлыг 591,500 (таван зуун ерэн нэгэн мянга таван зуун) төгрөгийг Засаг даргын нөөц болон бусад холбогдох зардлаас санхүүжүүлэхийг Нягтлан бодогч (С.Намшир)-т зөвшөөрсүгэй.

5. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг дарга Тамгын газрын дарга (Г.Батжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ч.САРАНГЭРЭЛ



Сумын Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 8 -ний өдрийн 1/28 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

**ҮСЧИН, ГОО САЙХАНЧ, МАНИКЮР НАРЫН УР
ЧАДВАРЫН УРАЛДААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Гүйцэтгэх ажил	Хугацаа	Хариуцах эзэн
1	Ажлын хэсэг, удирдамж, төлөвлөгөө төсөв батлуулах	11-р сарын 10-11	Б.Батжаргал Г.Уянга/ХАА/
2	Зуунмодын нутаг дэвсгэр дээр үсчин, гоо сайханч, маникюрын үйлчилгээ явуулдаг иргэн, ААН-ийн судалгаа авах	11-р сарын 09	Г.Уянга/ХАА/ Жаргалтогтох
3	Уралдаанд оролцогчдод удирдамж хэвлэл мэдээлэлээр цацах	11-р сарын 15-29	Б.Батжаргал Г.Уянга/ЦҮА/
4	Ажлын хэсэг хуралдуулах	11-р сарын 15	Г.Уянга/ХАА/ Д.Өнөрбаяр Б.Уянга
5	Уралдаанд оролцогчдыг бүртгэх, 60.000 төгрөгний мандат олгох	11-р сарын 22	Г.Уянга/ХАА/ Д.Өнөрбаяр М.Жаргалтогтох
6	УБ хотоос тоног төхөөрөмж авчрах	11-р сарын 28	Б.Батжаргал М.Жаргалтогтох Б.Лхагвасүрэн Б.Сарнайцэцэг
7	Хэвлэл, баннер, мандат, өргөмжлөл, батламж, хаягжуулах, дугаар хийх	11-р сарын 20-29	Б.Батжаргал Г.Уянга/ЦҮА/
7	Тэмцээн зохион байгуулах байр, бэлтгэл ажил хангах /ширээ, ширээний бүтээлэг, ширээ засах/	11-р сарын 28-29	Ажлын хэсэг
8	Тэмцээн эхлэхийн өмнө хөгжим, аппартур, техник тоног төхөөрөмж бэлэн болгох	11-р сарын 29	Ш.Батмөнх
9	Шагнал бэлтгэх	11-р сарын 29	Б.Уянга Д.Өнөрбаяр Б.Уянга
10	Шагнал гардуулах	11-р сарын 29	Ажлын хэсэг

АЖЛЫН ХЭСЭГ

Сумын Засаг даргын 2022 оны 11 дүгээр
сарын 8 -ний өдрийн 2 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт

**ҮСЧИН, ГОО САЙХАНЧ, МАНИКЮР-НАРЫН УР
ЧАДВАРЫН УРАЛДААНД ШААРДАГДАХ ТӨСӨВ**

№	Зардлын нэр	Хэмжи х нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ /мян.төг/
1. Бичиг хэргийн зардал					
1	Фото цаас	ш	30	250	7,500
2	Мандат гэр	ш	55	800	44,000
3	Баннер хэвлэл	м.кв	15	12,000	180,000
	Дүн				214,250
2. Шагналын сан мөнгө					
1	1-р байр	ш	3	100,000	300,000
2	2-р байр	ш	2	80,000	160,000
	Дүн				360,000
	Нийт дүн				591,500

ТӨСӨВ ХИЙСЭН:

ХАА-Н ТАСГИЙН МЭРГЭЖИЛТЭН:

/Г.УЯНГА/

ТӨСӨВ ХЯНАСАН:

НЯГТЛАН БОДОГЧ:

/С.НАМШИР/